

**“ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТОГТООЛ**

2023 оны 06-р сарын 14-ний өдөр

№01

Улаанбаатар хот

Компанийн дүрмийн төслийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг, 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх хэсэг, 2023 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын Тооллогын комиссын тогтоол №2-г тус тус үндэслэн Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаас **ТОГТООХ НЬ**:

- Нэг. ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР ХК-ийн (цаашид “компани” гэх) дүрмийг энэхүү тогтоолын иэгдүгээр хавсралтаар баталсугай.
- Хоёр. Компанийн дүрмийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга болон Гүйцэтгэх захирал /Ц.Ганбат/ нарт үүрэг болгосугай.
- Гурав. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын шийдвэрийг хэрэгжүүлж хуульд заасан хугацаанд зохих журмын дагуу холбогдох бүртгэлийн байгууллагад хүргүүлж, бүртгүүлэхийг Гүйцэтгэх захирал /Ц.Ганбат/, Өмгөөллийн “Сноу Хилл Консалтанс” ХХН-ийн хуульч А.Солонго, А.Тайван нарт, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа удирдлага хариуцсан захирал албан тушаалтай /З.Байгалмаа/ нарт тус тус үүрэг болгосугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН

ХУРЛЫН ДАРГА

П.НЯМДОРЖ





“ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ДҮРЭМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. “ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР” ХК нь /“Компани”/ Монгол Улсын Иргэний хууль, Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан холбогдох дүрэм, журам болон бусад хууль тогтоомж, энхүү дүрэм (Дүрэм)-ийн хүрээнд ашгийн телее аж ахуйн үйл ажиллагаа явуулах нээлттэй хувьцаат компани (ХК)-ийн хэлбэрээр зохион байгуулагдсан хуулийн этгээд мен.
- 1.2. Энэхүү Дүрмийн зорилт нь Компанийг үүсгэн байгуулах, дотоод үйл ажиллагаатай холбоотойгоор өөрчлөн зохион байгуулах, Компанийн удирдлага, зохион байгуулалт тэдгээрийн чиг үүрэг, үйл ажиллагааны үндсэн зарчим, хяналтын бүтэц, хувьцаа эзэмшигчдийн бүрэн эрх, үүрэг, хариуцлагыг тогтоох, Төвлөлөн удирдах зөвлөл (ТҮЗ)-ийн хурлын бүрэн эрх, үүрэг, хариуцлагыг тогтоох болон Компанийн татан буулгахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
- 1.3. Компанийн Дүрэм нь Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн акттай харшлах, зөрчилдөх тохиолдолд Компани нь холбогдох хууль тогтоомжийн актад нийцүүлэн энэхүү Дүрэмд оруулах нэмэлт, өөрчлөлтийн талаарх мэдэгдлийг бүх хувьцаа эзэмшигчдэд хуанлийн 14 хоногийн дотор бичгээр хүргүүлнэ.

ХОЁР. КОМПАНИЙН ОНООСОН НЭР, ОРШИН БАЙГАА ХАЯГ

- 2.1. Компанийн оноосон нэрийг “ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР” ХК, англиар GAZAR SHIM INDUSTRY Joint Stock Company гэх бөгөөд Компани нь хуулийн этгээдийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх, үйл ажиллагаа явуулах, гэрээ хэлцэл хийх зэрэг бүх тохиолдолд оноосон нэрийнхээ дараа “ХК” гэсэн тэмдэглэгээг хэрэглэн.
- 2.2. Компанийн ерөнхий захиргаа, удирдлага оршин байрлаж байгаа хаяг нь Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20-р хороо, Үйлдвэрийн баруун бүс, 66/1 66/2 байна.
- 2.3. Компанийн эрхэм зорилго: Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг газар тариалангийн салбарын ашигт ажиллагаатай хослуулан, байгаль орчинд ээлтэй үйлдвэрлэл эрхлэх, Монгол хүний эрүүл мэндэд тустай, тэжээллаг, амт чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэж, хэрэглэгчдэд нийлүүлэх замаар хувьцаа эзэмшигчдийн өвөөжийг нэмэгдүүлэх, мэргэшсэн, ёс зүйтэй, ур чадвартай хамт олон бүрдүүлэх.
- 2.4. Компанийн алсын хараа: Дэвшилтээ технологи, сайн чанарын ургац, мэргэшсэн хамт олны туршлагад тулгуурлан инновацлаг, шинэлэг бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлэх, байгаль орчинд залтай үйлдвэрлэлийн үйл ажиллагааг эрхэмлэх. Компанийн засаглалын зарчим: Компани нь дотоод үйл ажиллагаандaa засаглалын дараах 9 зарчмыг дагаж мөрдөх үүрэг хулээнэ.

- 2.4.1. ТУЗ нь олон талт ур чадвар, мэдлэг, туршлага, хараат бус байдал зэргийг зохистойгоор хангасан, алсын хараатай, бүтээлч бүтэцтэй байх;
- 2.4.2. ТУЗ нь үйл ажиллагаагаа тодорхой чиг үүрэг хариуцсан өөрийн дэргэдэх хороодоор дамжуулан хэрэгжүүлж, эцсийн хариуцлагыг хүлээх;
- 2.4.3. ТУЗ нь санхүүгийн болон үйл ажиллагааны тайлагнال, мэдээллийн ил тод байдлын үнэн зөв, бүрэн бүтэн, тэнцвэртэй байдлыг хангах арга хэмжээ авч ажиллах;
- 2.4.4. ТУЗ нь аудит, хяналтын тогтолцооны хараат бус, үр дүнтэй байдлыг хангаж ажиллах;
- 2.4.5. Компани эрсдэлийн удирдлагын тогтолцоог зүй зохистой, хараат бус байдлаар зохион байгуулж, тогтолцооны үр дүнтэй байдалд хяналт тавих;
- 2.4.6. ТУЗ болон гүйцэтгэх удирдлагын цалин урамшууллын хэмжээ нь Компанийн алсын хараа, онцлогт тохирсон, шударга, ил тод байх;
- 2.4.7. Компани нь үйл ажиллагаагаа явуулахдаа оролцогч талуудын эрх ашгийг хүндэтгэх;
- 2.4.8. ТУЗ-ийн гишүүд Компанийн бизнесийн ёс зүй, хариуцлагыг өндөр хэм хэмжээг тогтоож, өөрсдөө манлайлан гүйцэтгэх удирдлага, ажилтанд мердлэг болгон хэвшүүлэх;
- 2.4.9. Компани болон ТУЗ нь хувьцаа эзэмшигчийн эрхийг хүндэтгэн тэгш хандаж, холбогдох мэдээлэл авах болон эрхээ хэрэгжүүлэх бололцоогоор хангах.

ГУРАВ. КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ

- 3.1. Компани нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль болон бусад хууль тогтоомжид заасны дагуу дараах үндсэн аж ахуйн үйл ажиллагаануудыг эрхлэн явуулна. Үүнд:
 - 3.1.1. Жимс болон тэмс, хүнсний ногоо боловсруулалт, хадгалалт"- жимс болон хүнсний бусад ногоогоор шүүс, баяжмал зэрэг бүтээгдэхүүн хийх, хатаах, хөлдөөх, боловсруулан савлан хадгалах үйл ажиллагаа Жимсний чанамал, мармелад үйлдвэрлэх;
 - 3.1.2. Хүнсний беений болон жижиглэнгийн худалдаа;
 - 3.1.3. Хүнсний ногоо тариалах, худалдах;
 - 3.1.4. Жимс, жимсгэнэ тариалах, худалдаа;
 - 3.1.5. Үндаа жүүс, үйлдвэрлэл;
 - 3.1.6. Цайны газар;
 - 3.1.7. Хүнсний дэлгүүр эрхлэх;
 - 3.1.8. Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл;

*Газар Шим Улдээр ХК-ийн Хувьцаа
эзэмшигчдийн эзлэжин бус хурлын 2023 оны
06 сарын 14-ний өдрийн №1 тоот Тогтоолын
Хавсралт №1*

- 3.1.9. Барьцаалан зээлдүүлэх үйлчилгээ;
 - 3.1.10. Газар тариалан, мал аж ахуй, ан агуулур, түүнтэй холбогдох үйлчилгээ;
 - 3.1.11. Цайны үйлдвэрлэл, худалдаа;
 - 3.1.12. Фермерийн аж ахуйн эрхлэх;
 - 3.1.13. Хүлэмжийн аж ахуйн эрхлэх;
 - 3.1.14. Төлбер гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа.
- 3.2. Компани нь дараах үйл ажиллагааг тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхлэх бөгөөд тухайн зөвшөөрлийн нөхцөл, хугацааг чанд мөрдеж ажиллана.
 - 3.3. Компани нь өөрийн зорилго болон эрхлэх үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхтэй шууд буюу шууд бус холбоотой, хууль тогтоомжоор хориглоогүй бүхий л төрлийн үйл ажиллагааг эрхлэх болон ажил гүйлгээг хийх бүрэн эрхтэй байна.

ДӨРӨВ. КОМПАНИЙН ЭРХ ХЭМЖЭЭ

- 4.1. Компанийг Улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлэн Улсын бүртгэлийн гэрчилгээ авсан өдрийг Компани үүсгэн байгуулагдсан өдер гэж тооцно.
- 4.2. Компани үүсгэн байгуулагдсан өдрөөс эхлэн Хувьцаа эзэмшигчээс тусгайлсан өмчилсөн өөрийн эд хөрөнгөтэй, үйл ажиллагааныхаа хүрээнд эрх эдэлж, үүрэг хүлээх ба түүнээс үүсэн гарах аливаа үүргийг өөрийн эд хөрөнгийн хэмжээгээр хариуцах, шүүх, арбитрт өөрийн нэрийн өмнөөс оролцох эрхийн чадвартай, банканд өөрийн нэр бүхий данстай, бие даасан тайлан бланстай, Дүрэмд заасан үйл ажиллагааг явуулах эрх зүйн чадвартай байна.
- 4.3. Компани нь өөрийн тамга, цорын ганц тэмдэг (лого), бичгийн хэвлэмэл хуудастай байна. Гүйцэтгэх захирал нь Компанийн тамга ашиглах аюулгүй ажиллагааг хангаж ажиллана. Албан албан бичгэн дээр дарагдах Компанийн тамга нь эрх бүхий этгээд. Гүйцэтгэх захирал эсхүл тэдгээрийн эрх олгсон этгээдийн гарын үсгээр баталгаажигдаж гэрчлэгдэнэ.
- 4.3. Компанийн эд хөрөнгө нь эзэмшиж байгаа эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхээс бүрдэх бөгөөд Компани нь хүлээсэн үүргээ өөрийн өмчлөлд байгаа бүх эд хөрөнгөөрөө хариуцах ба Хувьцаа эзэмшигчдийн өр болон хүлээх үүргийг хариуцахгүй.
- 4.4. Компани нь Монгол Улсад болон гадаад улсад өөрийн хараат, охин компани, салбар төлөөлөгчийн газрыг Компанийн тухай хуулийн дагуу байгуулах эрхтэй байна. Хараат болон охин компани нь бие даасан хуулийн этгээдийн эрхийг эдлэх бөгөөд тэдгээр нь эрх бүхий байгууллагаас баталсан дүрмийн дагуу бие дааж үйл ажиллагаагаа явуулна. Салбар болон төлөөлөгчийн газар нь бие даасан хуулийн этгээдийн эрхийг эдлэхгүй бөгөөд Компанийн баталсан дотоод журмын дагуу үйл ажиллагаагаа эрхлэн явуулна.

*Газар Шим Үйлдвэр ХК-ийн Хувьцаа
эзэмшигчдийн эзлжсит бус хурлын 2023 оны
Об сарын 14-ний өдрийн №1 тоот Тогтоолын
Хавсралт №1*

- 4.5. Компани нь Санхүүгийн Зохицуулах Хорооноос авсан зөвшөөрлийг үндэслэн салбар, төвлөгөөний газар байгуулж болно. Салбар, нэгжүүд нь тусдаа улсын төрчилгээ, тамга, тэмдэг, үйл ажиллагааны журамтай байна.

ТАВ. КОМПАНИЙН ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГӨ БОЛОН ӨӨРИЙН ХӨРӨНГӨ

- 5.1. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө нь Компанийн нийт гаргасан бөгөөд эргэлтад байгаа хувьцаанаас бүрдэх бөгөөд хувь нийлүүлсэн хөрөнгөд зарласан болон эргүүлэн худалдаж авсан халаасны хувьцаа хамаарахгүй.
- 5.2. Компанийн зарласан болон гаргасан хувьцаа нь нэг бүр нь 0.11 төгрөгийн нэрлэсэн үнз бүхий 1.198.113.207 (нэг тэрбум нэг зуун ерэн найман сая нэг зуун авсан гурван мянга хоёр зуун долоо) ширхэг энгийн хувьцаанаас бүрдэх ба Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь 131.792.452.77 (нэг зуун гучин нэгэн сая долоон зуун ерэн хоёр мянга дервэн зуун тавин хоёр төгрөг далан долоон менге) төгрөг байна..
- 5.3. Компани нь Санхүүгийн Зохицуулах хорооноос тогтоосон хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээ, үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг хангаж ажиллана.
- 5.4. Компани нь давуу эрхийн хувьцаа гаргаж болно. Давуу эрхийн хувьцааны тоо, нэрлэсэн үнэ, зориулалт, тухайн төрлийн хувьцаа эзэмшигчдэд олгох давуу эрх зэргийг тухай бүр Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ.
- 5.5. Компани нь өөрийн хуримтлагдсан ашгийн хэмжээгээр хувь нийлүүлсэн хөрөнгөө нэмэгдүүлж болно. Шаардлагатай тохиолдолд хувь нийлүүлсэн хөрөнгөд шинээр хөрөнгө оруулалт оруулж болно.
- 5.6. Компани тодорхой нэхцэлөөр хаалттай захиалгын үндсэн дээр хувьцаа болон бусад үнэт цаас гаргаж болно.
- 5.7. Компани гүйлгээнд гаргасан өөрийн хувьцааг эргүүлэн худалдан авсан бол здгээр хувьцааг халаасны хувьцаа гэж үзэх бөгөөд балансад хувь нийлүүлсэн хөрөнгийн хэсэгт нэрлэсэн үнээр хасах тэмдэгтэйгээр харуулна.

ЗУРГАА. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ, ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА

- 6.1. Компанийн энгийн хувьцааг зохих журмын дагуу худалдан авч эзэмшсэн этгээд компанийн хувьцаа эзэмшигч болно.
- 6.2. Компаниас хууль тогтоомжийн дагуу ногдол ашиг хуваарилахаар ТУЗ-аас шийдвэр гарсны дагуу ногдол ашиг авах эрхтэй байна.

*Газар Шин Уйлдвэр ХК-ийн Хувьцаа
эзэмшигчдийн эзлжит бус хурлын 2023 оны
06 сарын 14-ний өдрийн №1 тоот Тогтоолын
Хавсралт №1*

- 6.3. Компанийн хувьцаа эзэмшигч нь өөрийн нэр, оршин суугаа хаяг болон өөрийн эзэмшилдээ байгаа үнэт цаасны тоо, тэдгээрт орсон нэмэлт, өөрчлөлтийн талаар бүртгэл хөтлөх этгээдэд зохих журмын дагуу мэдэгдэх зэрэг үүрэг хулзэнэ.
- 6.4. Дүрмийн 5.7 дахь хэсэгт заасан асуудал болон хувьцаа эзэмшигчдэд хувьцааг тэргүүн зэлжид худалдан авах эрхийг эдлүүлэхгүй байх асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож байгаа саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн дийлэнх олонхийн саналаар шийдвэрлэнэ.
- 6.5. Хувьцаа эзэмшигч нь Компаниас нэмж гаргасан хувьцаа, хувьцаанд хөрвөх үнэт цаасыг тодорхий нехцэлөөр тэргүүн зэлжид худалдан авах эрхтэй байна. Энэ давуу эрхийг Компанийн тухай хуулийн 38-р зүйлд заасан журмын дагуу хэрэгжүүлэх үүргийг ТУЗ хулзэнэ.
- 6.6. Компанийн эд хөрөнгө нь эзэмшиж байгаа эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхээс бүрдэх бөгөөд компани нь эдгээр бүх эд хөрөнгөөрөө хариуцлага хулзэнэ.
- 6.7. Компани нь Хувьцаа эзэмшигчдийн хүлээх үүргийг хариуцахгүй бөгөөд Хувьцаа эзэмшигч нь Компанийн хүлээх үүргийг хариуцахгүй.
- 6.8. Компанийн хувьцаа эзэмшигчид нь гагцхүү өөрийн эзэмшиж буй хувьцааны хэмжээгээр эрсдэл, хариуцлага хулзэнэ.
- 6.9. Компанийн энгийн хувьцаа эзэмшигч нь дараах эрх эзлэнэ.
 - 6.9.1. Хувьцаа эзэмшигчдийн хурал зарлах, энэ санал хураалт явуулах шийдвэр гаргах үед ТУЗ-еес тогтоосон "бүртгэлийн өдөр" Компанийн хувьцааг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч хуралд оролцож, хэлэлцэж буй асуудлаар өөрийн эзэмшиж буй саналын хувьцаатай хувь тэнцүүлэн санал өгөх;
 - 6.9.2. ТУЗ-еес ногдол ашиг олгохоор шийдвэрлэсэн үед эзэмшиж буй хувьцаанд оногдох ногдол ашиг авах, ногдол ашиг олгохоор зарласан боловч хууль журамд заасан хугацаандаа олгохгүй бол алданги төлөхийг шаардах;
 - 6.9.3. Компанийг татан буулгах үед Компанийн тухай хуулийн 28 дугаар зүйлд тогтоосон журмын дагуу үндсэн эд хөрөнгийг худалдсанаас опсон орлогоос хувь хуртэх;
 - 6.9.4. Компаниас нэмж гаргасан хувьцаа, хувьцаанд хөрвөх үнэт цаасыг Компанийн тухай хуулийн 38 дугаар зүйлд заасан журмын дагуу тэргүүн эзлжинд худалдан авах.
 - 6.9.5. Дор дурдсан асуудлаар гаргасан хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийн зсрэг саналтай байсан, эсвэл санал хураалтад оролцоогүй хувьцаа эзэмшигч

*Газар Шим Үйлдвэр ХК-ийн Хувьцаа
эзэмшигчдийн эзлжит бус хурлын 2023 оны
06 сарын 14-ний одрийн №1 тоот Тогтоолын
Хавсралт №1*

бүр өөрийн эзэмшиж байгаа хувьцааг эргүүлэн авахыг Компаниас шаардах эрхтэй. Үүнд:

- 6.9.5.1. Нийлэх, нэгдэх, хуваах, болон хязгаарлагдмал хариуцлагатай компанийг хувьцаат компани болгон өөрчлөх хэлбэрээр Компанийг өөрчлен байгуулах болсон бол;
- 6.9.5.2. Хэлцэл хийхийн өмнөх сүүлийн балансын активын нийт дүнгийн 25 хувиас дээш зах зээлийн үнэтэй эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдан авах захиран зарцуулах болон барьцаалахтай холбогдсон хэлцэл, Компанийн урьд гаргасан энгийн хувьцааны 25 хувиас дээш хэмжээний энгийн хувьцаа, энгийн хувьцаа авах эрхийн бичиг буюу энгийн хувьцаанд хөрвөх үнэт цаас гаргасан зэргээр их хэмжээний хэлцэл хийсэн бол;
- 6.9.5.3. Компанийн хувьцаа эзэмшигчдийн эрхийг хязгаарласан нэмэлт, өөрчлөлтийг Компанийн дүрэмд оруулсан, эсхүл ийм агуулгатай дурмийн шинэчилсэн найруулгыг баталсан бол;
- 6.9.5.4. Нэг хувьцаа эзэмшигч түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдийн хамт Компанийн энгийн хувьцааны 75-аас дээш хувийг эзэмшиж байгаа тохиолдолд бусад энгийн хувьцаа эзэмшигчид Компанид хувьцаагаа эргүүлэн авахыг шаардах эрхтэй.
- 6.9.6. Энгийн хувьцааны 10 хувиас дээш хувьцаа эзэмшиж буй этгээд хувьцаа эзэмшигчдийн эзлжит бус хурлыг хуралдуулахаар ТУЗ-д санал хүргүүлэх, ТУЗ эн саналыг үндэслэлгүйгээр хүлээн аваагүй тохиолдолд өөрөө зарлан хуралдуулах, хувьцаа эзэмшигчдийн хурал зарлагдсан үед хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг шаардан гаргуулах;
- 6.9.7. Хувьцаа эзэмшигч нь улирал бүр Компанийн санхүүгийн тайлантай танилцах эрхтэй.
- 6.9.8. Хууль тогтоомж болон энэхүү дүрмээр тогтоосон бусад эрх.

ДОЛОО. КОМПАНИЙН ҮНЭТ ЦААС ГАРГАХ, ХУДАЛДАХ, ЭРГҮҮЛЭН АВАХ

- 7.1. Компани нь энгийн хувьцаанаас гадна өрийн бичиг, хувьцаанд хамаарах бусад үнэт цаас гаргаж болно.
- 7.2. Компанийн үйл ажиллагааг өргөтгөх, шинэ бизнес эрхлэх, нэмэгдэл хөрөнгийн эх үүсвэр бий болгох зорилгоор Компанийн зарласан хувьцааны төрөл болон хэмжээнд багтаан хувьцаа гаргах, гүйлгээнд оруулах асуудлыг ТУЗ шийдвэрлэнэ.

- 7.3. Үнэт цаасыг нийтэд санал болгон худалдахаар шийдвэрлэсэн бол Үнэт цаасны зах зээлийн тухай хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэнэ.
- 7.4. Үнэт цаас гаргах тухай шийдвэрт үнэт цаас гаргах болсон үндэслэл, шалтгаан, гаргах үнэт цаасны төрөл, тоо нэрлэсэн үнэ, үнийн дун, гаргах хугацаа нехцел зэргийг заасан байна.
- 7.5. Компанийн хувьцаа эзэмшигч нь дүрмийн санд оруулсан хувь херенгийнхэе хэмжээгээр санхуугийн хариуцлага хүлээж, алдагдлыг нехнэ.
- 7.6. Хувьцаа эзэмшигчдийн хувьцааны бүртгэлийг үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад бүртгүүлж, бүртгалийг хөтлүүлнэ.
- 7.7. Компани нь хувь нийлүүлсэн херенгийн хэмжээг дараах байдлаар нэмэгдүүлж, хорогдуулж болно:
 - 7.7.1. Хувьцааны нэрлэсэн үнийг вөрчлөх;
 - 7.7.2. Хувьцаа нэмж гаргах болон худалдан авсан халаасны хувьцааг хүчингүй болгох;
 - 7.7.3. Өөрийн хуримтлагдсан ашгийн хэмжээгээр хувь нийлүүлсэн херенгее нэмэгдүүлэх.
- 7.8. Компанийн тухай хуулийн 43-р зүйлд зааснаас бусад тохиолдолд Хувьцаа бусад үнэт цаасны нийт үнийг Компанийн тухай хуулийн 55 дугаар зүйлд заасны дагуу ТУЗ тогтооно.
- 7.9. Компаниас шинээр гаргаж байгаа үнэт цаасны төлбөрийг бэлэн менгэ, үнэт цаас, эд херенгэ болон оюуны өмчийг үнэлзх хэлбэрээр хийж болно. Үнэт цаасны төлбөрт тооцох менген бус херенгийн үнэлгээг уг хэлбэрээр хийхийг сонирхогч бус ТУЗ-ийн гишүүдийн дийлэнх олонхийн саналаар тогтооно.
- 7.10. ТУЗ-ийн шийдвэрээр Компани нь өөрийн гаргасан үнэт цаасыг эзэмшигчтэй нь тохиролцсоны үндсэн дээр эргүүлэн худалдаж авч болно. Компани нь энгийн хувьцаанаас бусад үнэт цаасыг бүхэлд нь эсвэл зарим хэсгийг худалдан авч болно. Харин энгийн хувьцааны хувьд тухайн жилд гүйлгээнд байсан нийт хувьцааны 25 хувиас хэтрэхгүй байна. Худалдан авсан өөрийн хувьцааг халаасны хувьцаа гэнэ.
- 7.11. Компани нь дараах нехцелд өөрийн гаргасан үнэт цаасыг эргүүлэн худалдаж авах шийдвэр гаргаж болно.
 - 7.11.1. хуульд заасан үүргийнхээ дагуу эргүүлэн авах энгийн хувьцаа бол;
 - 7.11.2. үнэт цаасаа эргүүлэн авсны дараа төлбөрийн чадвартай байвал;

- 7.11.3. Компанийн веерийн хөрөнгийн хэмжээ нь Компанийн тухай хуулийн 32 дугаар зүйлд заасан доод хэмжээ болон гаргасан давуу эрхийн хувьцааны төлөгдөөгүй ногдол ашиг, татан буулгалтын үнэ зэргийн нийлбэрээс их бол.
- 7.12. Компанийн хувьцаа эзэмшигч нь бусад хувьцаа эзэмшигчийн саналыг харгалзахгүйгээр веерийн эзэмшиж байгаа хувьцаагаа чөлөөтэй захиран зарцуулах эрх здэлнэ.
- 7.13. Компанийн хувьцаа эзэмшигч нь хувьцаагаа үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагаар дамжуулан худалдахаас бусад хэлбэрээр шилжүүлсэн бол хувьцаа эзэмшигчийн бүртгэл хөтлөх этгээд буюу үнэт цаасны хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагад бүртгүүлэх үүрэгтэй.

НАЙМ. КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

- 8.1. Компанийн эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал (ХЭХ) байна.
- 8.2. ХЭХ нь эзлжит ба эзлжит бус байх бөгөөд эзлжит хурлыг ТУЗ нь Компанийн тухай хуульд заасан хугацаанд буюу санхүүгийн жил дууссанаас хойш 4 сарын дотор жилд нэг удаа зарлан хуралдуулна.
- 8.3. Хувьцаа эзэмшигчдийн эзлжит бус хурлыг Компанийн тухай хуулийн 61 дүгээр зүйлд заасны дагуу ТУЗ-өөс шийдвэрлэж хуралдуулна.
- 8.4. ХЭХ-аар энэ дүрэмд өөрөөр заагаагүй бол Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1 дэх хэсэгт заасан асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ.
- 8.5. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг даргалах этгээд нь тухайн хурлыг хуралдуулах санал гаргасан этгээд байх бөгөөд түүнийг тухайн хурал хуралдуулах шийдвэрт тусгана.
- 8.6. Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарах дараах асуудлыг хуралд оролцож байгаа саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн саналын энгийн олонхийн саналаар шийдвэрлэнэ.
 - 8.6.1. ТУЗ-ийн гишүүнийг сонгох, бүрэн эрхийг нь хугацаанаас өмнө дуусгавар болгох;
 - 8.6.2. компанийн тухай хуулийн 38 дугаар зүйлд заасны дагуу хувьцаа эзэмшигчдэд хувьцаа, бусад үнэт цаасыг тэргүүн эзлжинд худалдан авах эрх эдлүүлэх эсэх;
 - 8.6.3. компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцүүлэх;
 - 8.6.4. компанийн веерийн гаргасан хувьцааны 5-аас дээш хувийг худалдан авахыг зөвшөөрөх;
 - 8.6.5. ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох;

- 8.6.6. ТУЗ-ийн шийдвэрээр хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэхээр оруулсан бусад асуудал
- 8.7. Дараах асуудлууд нь зөвхөн хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарах бөгөөд хуралд оролцож байгаа саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийг дийлэнх олонхийн саналаар шийдвэрлэнэ.
- 8.7.1. компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу түүний шинэчилсэн найруулгыг батлах;
- 8.7.2. нийлэх, нэгдэх, хуваах, тусгаарлах буюу өөрчлөх хэлбэрээр компанийг өөрчлен байгуулах;
- 8.7.3. компанийн ёрийг хувьцаагаар солих, нэмж хувьцаа гаргах, түүний тоог тогтоох;
- 8.7.4. компанийг татан буулгах болон татан буулгах комиссыг томилох;
- 8.7.5. хувьцааг хуваах буюу нэгтгэх;
- 8.8. Хурлын тухай мэдээллийг нийтэд хүргэх, хуралд оролцох гишүүдийг тодруулах, санал авах ажиллагааг Компанийн тухай хууль, Компаниас баталсан журмын дагуу явуулна.
- 8.9. Хувьцаа эзэмшигч нь Компанийн тухай хуулийн 68 дүгээр зүйлд заасан журмын дагуу ХЭХ-д өөрийн биеэр буюу Иргэний хуулийн 63-64 дүгээр зүйлд зааснаар бичгээр олгосон хуулийн хүчин төгөлдөр итгэмжлэлийг үндэслэн өөр этгээдээр төлөөлүүлэн оролцуулж болно.
- 8.10. Хувьцаа эзэмшигч хурлаас гарах шийдвэрийн төсөлд саналын хуудсаар санал ирүүлсэн тохиолдолд түүнийг хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцсон гэж үзнэ. Уг санал нь Компанийн тухай хуулийн холбогдох шаардлагыг хангасан байна.
- 8.11. Саналын эрх бүхий энгийн хувьцааны арав буюу түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч нь Хувьцаа эзэмшигчдийн хурал зарлан хуралдуулахаар тогтоосон өдреес ажлын 1 хоногийн өмнө Хувьцаа эзэмшигчдийн зэлжит бус хурлаар хэлэлцэх асуудалд санал оруулах эрхтэй.
- 8.12. Компанийн саналын эрх бүхий хувьцааны 50-аас дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцсоноор хурал хүчин төгөлдөр болно. Хурлын ирцэд заасан хувь хурээгүй бол хурлыг хүчин төгөлдөр бус гэж үзэж хурлыг дахин хуралдуудах өдрийг товлож энэ тухай тэмдэглэл үйлдэж ТУЗ-ийн дарга, тэмдэглэл хөтлөгч гарын үсэг зурна. Хойшлогдсон хурлаас хэлэлцэх асуудлыг өөрчлөхгүй болно.

- 8.13. Хойшлогдсон хурлыг Компанийн тухай хуулийн 69.6-д заасан журмын дагуу ажлын 20 хоногийн дотор хуралдуулна. Өмнөх хуралд саналын хуудсаар ирүүлсэн саналыг хойшлогдсон хурлын ирц, санал хураалтын дүнд тооцно.
- 8.14. Саналын эрхтэй хувьцаа эзэмшигчийн 20 буюу түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч нар хуралд оролцсоноор Дүрмийн 8.13 дэх хэсэгт заасан хойшлогдсон хурал хүчин төгөлдөр болно.
- 8.15. Хувьцаат компани нь хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарах асуудлыг хурал хуралдуулахгүйгээр хувьцаа эзэмшигчдээс энээс санал хураалт явуулах замаар шийдвэрлэж болох бөгөөд энээс санал хураалтыг саналын хуудсыг ашиглан явуулна. Хувьцаа эзэмшигчдийн эзлжит хурлыг энээс санал хураалтаар орлуулахыг хориглоно.
- 8.16. Энээс санал хураалт явуулах шийдвэрийг ТУЗ гаргах бөгөөд энэхүү шийдвэрт Компанийн тухай хуулийн 73.3-т заасан асуудлыг тусгасан байна.
- 8.17. Энээс санал хураалтаар шийдвэрлэх асуудлыг тусгасан санал хураах хуудсыг хүлээн авах сүүлчийн өдреес ажлын 30-аас доошгүй хоногийн өмнө хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэдэг аргаар хувьцаа эзэмшигчдэд хүргүүлэх бөгөөд саналын хуудсыг хүлээн авах, санал тоолох ажлыг Тооллогын комисс хариуцан гүйцэтгэнэ.
- 8.18. Хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэл, тогтоолыг Компанийн тухай хуулийн 74 дүгээр зүйлд заасан журмын дагуу хетелж, Хувьцаа эзэмшигчдийн хурлын дарга баталгаажуулан гарын үсэг зурна.

ЕС. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ, ТҮҮНИЙ ЭРХ ХЭМЖЭЭ

- 9.1. Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт Компанийн эрх барих байгууллага нь Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ) байна. ТУЗ нь эрх хэмжээнийхээ дагуу хамгийн цөөндөө улирал бүр хуралдана.
- 9.2. ТУЗ нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.
 - 9.2.1. компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тогтоох;
 - 9.2.2. хувьцаа эзэмшигчдийн эзлжит болон эзлжит бус хурлыг зарлан хуралдуулах;
 - 9.2.3. хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал, саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэrsийн жагсаалтыг гаргах бүртгэлийн өдер болон хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулахтай холбогдох бусад асуудлыг шийдвэрлэх;
 - 9.2.4. компанийн зарласан хувьцааны төрөл болон тоонд багтаан хувьцаа гаргах;
 - 9.2.5. компанийн дурамд заасан хувьцаанд хамаарах болон бусад үнэт цаас гаргах;

- 9.2.6. эд хөрөнгийн болон эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг тогтоох;
 - 9.2.7. өөрийн гаргасан хувьцаа, бусад үнэт цаасыг худалдан авах буюу эргүүлэн авах;
 - 9.2.8. компанийн гүйцэтгэх удирдлагыг сонгох, өөрчлөх, түүний бүрэн эрхийг тогтоох;
 - 9.2.9. компанийн гүйцэтгэх удирдлагатай байгуулах гэрээний нөхцөл, түүнд олгох шагнал, урамшуулал, хариуцлагын хэмжээг тогтоох;
 - 9.2.10. аудитын байгууллагыг сонгож, түүнтэй байгуулах гэрээний нөхцелийг тогтоох;
 - 9.2.11. компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргаж, түүнийг хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж батлуулах;
 - 9.2.12. ногдол ашгийн хэмжээ, түүнийг төлөх журмыг тодорхойлох;
 - 9.2.13. төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны болон компанийн засаглалын дотоод журмыг батлах;
 - 9.2.14. компанийн салбар болон төлөөлөгчийн газар байгуулах
 - 9.2.15. компанийг өөрчлөн байгуулах талаар хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийн теслийг бэлтгэх, гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх;
 - 9.2.16. их хэмжээний хэлцэл хийх зөвшөөрөл олгох;
 - 9.2.17. сонирхлын зерчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох;
 - 9.2.18. Компанийн тухай хууль болон компанийн дүрмээр тогтоосон бусад асуудал.
- 9.3. ТУЗ нь нийт 9 гишүүнтэй байх бөгөөд тэдгээрийн 3 гишүүн нь хараат бус гишүүн байна.
 - 9.4. ТУЗ-ийн гишүүдийн дийлэнх олонхоор ТУЗ-ийн дарга гишүүдийн дотроос сонгоно.
 - 9.5. ТУЗ-ийн гишүүнийг Хувьцаа эзэмшигчийн хурлаар 3 (гурван) жилийн хугацаатай сонгоно. Гишүүдийг сонгохдоо санал хураах кумулятив аргыг хэрэглэнэ.
 - 9.6. ТУЗ-аас тогтоол гаргах бөгөөд түүнд ТУЗ-ийн дарга гагцхүү гарын үсэг зурж баталгаажуулна.
 - 9.7. Гишүүн нь удаан хугацаагаар үүргээ биелүүлж чадахгүй болсон тохиолдолд ТУЗ-өөс түүний оронд өөр хүнийг түр томилно.
 - 9.8. ТУЗ-ийн дарга нь:
 - 9.8.1. ТУЗ-ийн үйл ажиллагааг зохион байгуулж, түүний хурлыг хуралдуулах, хурал даргалах, хурлын тэмдэглэл хөтлүүлэх, хяналт тавих зэрэг Компанийн тухай хуульд заасан эрх эзлж, үүрэг хүлээнэ.

*Газар Шим Үйлдвэр ХК-ийн Хувьцаа
эзэмшигчдийн эзлжит бус хурлын 2023 оны
06 сарын 14-ний өдрийн №1 тоот Тогтоолын
Хавсралт №1*

- 9.9. ТУЗ-ийн хурлын бүрэн эрх, хуралтай холбоотой асуудлыг Компанийн тухай хууль болон "ТУЗ-ийн үйл ажиллагааны журам"-д заасны дагуу зохицуулна.
- 9.10. ТУЗ-ийн хурлыг ТУЗ-ийн дарга, түүний гишүүд. Компанийн гүйцэтгэх захидал болон ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасан бусад этгээдийн шаардлага, санаачилгаар хуралдуулна. ТУЗ энээс санал хураалтаар шийдвэр гаргаж болно.
- 9.11. ТУЗ нь ТУЗ-ийн нарийн бичгийн даргатай байх бөгөөд түүнийг ТУЗ-ийн дарга томилно. ТУЗ-ийн нарийн бичгийн үйл ажиллагаатай холбоотой асуудлыг ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар зохицуулна.
- 9.12. ТУЗ-ийн гишүүдийн дийлэнх олонх оролцсоноор ТУЗ-ийн хурал хүчин төгелдөр болно. ТУЗ-ийн гишүүд асуудлыг дийлэнх олонхийн саналаар шийдвэрлэнэ.
- 9.13. ТУЗ-ийн хэлэлцэж шийдвэрлэсэн хүчин төгелдөр шийдвэргүйгээр ТУЗ-ийн дарга нь дангаараа эсхүл аль нэг гишүүн болон зарим гишүүд хамтран ТУЗ-ийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх, бүрэн эрхэд нь хамаарах асуудлаар шийдвэр гаргах буюу ТУЗ-өөр сонгогдоогүй тохиолдолд ТУЗ-ийн байр суурийг төлөвлөх эрхгүй.
- 9.14. ТУЗ нь хуралдаанаар хурлын тэмдэглэл хетлөх бөгөөд тэмдэглэлд хуралд оролцсон ТУЗ-ийн гишүүд, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга гарын үсэг зурах бөгөөд бичгээр саналаа өгсөн гишүүдийн саналыг ТУЗ-ийн хурлын тэмдэглэлд хавсаргана.
- 9.15. ТУЗ-ийн шийдвэр нь тогтоолын хэлбартай байх бөгөөд ТУЗ-ийн дарга гарын үсэг зурж баталгаажуулна.
- 9.16. ТУЗ-ийн гишүүд нь Компанийн тухай хуульд заасан эрх бүхий албан тушаалтны хүлээх үүргийг хэрэгжүүлэхээс гадна, дараах үүргийг гүйцэтгэнэ. Үүнд:
 - 9.16.1. Компанийн ашиг сонирхлын төлөө, үнэнч шударгаар ажиллах;
 - 9.16.2. ажил үүргээ гүйцэтгэх явцдаа олж мэдсэн нууц болон нийтэд тараагдаагүй мэдээллийг өөрийн хувийн ашиг сонирхол буюу бусад этгээдийн ашиг сонирхлын үүднээс ашиглахгүй байна;
 - 9.16.3. ТУЗ-д аливаа сонирхлын зөрчлийн талаар мэдээллээ бичгээр мэдэгдэх;
 - 9.16.4. өрсөлдөгч Компанийн ТУЗ-ийн гишүүн, ажилтан, албан хаагчаар ажиллахгүй байх;
 - 9.16.5. ТУЗ-ийн хуралд идэвхитэй оролцож, ажлын туршлага, өөрийн мэдлэг, ур чадвар, неец болопцоог дайчлах, хувьцаа зээмшигчдийн хуралд ажлаа тайлагнах үүрэгтэй.

- 9.17. ТУЗ нь байнгын үйл ажиллагаатай Аудитын хороо, Нэр давшүүлэх, Цалин, урамшууллын хороодтой байна. Хороодын үйл ажиллагаатай холбоотой асуудлыг ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар зохицуулна.
- 9.18. ТУЗ нь хороодын бүтэц, бүрэлдэхүүнийг Компанийн тухай хуулийн 81.2 дахь хэсэгт заасны дагуу томилно.
- 9.19. ТУЗ-ийн дэргэдэх хороод нь тодорхой чиг үүрэгтэй байх бөгөөд тухайн асуудлаар дүгнэлт гаргаж ТУЗ-д танилцуулах, Компанийн тухай хуульд заасан асуудлаар шийдвэр гаргах бүрэн эрхтэй байна.
- 9.20. ТУЗ-ийн дэргэдэх хороодын чиг үүрэг, бүрэн эрх хэмжээ болон үйл ажиллагааны журмыг ТУЗ батална.
- 9.21. ТУЗ-ийн гишүүн нь тухайн жилд гурав болон түүнээс дээш удаа хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ТУЗ-ийн хуралд биеэр оролцоогүй, аливаа хэлбэрээр саналаа өвөөгүй мөн Компанийн холбогдох үйл ажиллагаа, хувьцаа зээшигчдийн хуралд оролцоогүй, идавхи хариуцлагагүй үйл ажиллагаа явуулсан тохиолдолд ТУЗ-ийн холбогдох хороо нь уг гишүүний бүрэн эрхийн асуудлыг авч хэлэлцэх үүрэгтэй бөгөөд ТУЗ уг гишүүнийг бүрэн эрхийн хугацаанаас өмнө чөлөөлөх эрхтэй.

АРАВ. ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА, ТҮҮНИЙ ЭРХ ХЭМЖЭЭ

- 10.1. Компанийн гүйцэтгэх удирдлагыг ТУЗ-өөснөн сонгосон Гүйцэтгэх захирал хэрэгжүүлэх ба Гүйцэтгэх захирал нь энэ дүрэм болон ТУЗ-тэй байгуулсан гэрээний дагуу өөрийн эрх хэмжээний хүрээнд Компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.
- 10.2. ТУЗ-ийн зөвшөөрсөн тохиолдолд Гүйцэтгэх захирал өөр компани, аж ахуйн нэгжийн удирдлагад давхар ажиллаж болно.
- 10.3. Гүйцэтгэх удирдлагын ТУЗ-тэй байгуулсан гэрээнд гүйцэтгэх удирдлагын эрх, үүрэг, хариуцлагын хэмжээ, хязгаар, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл, хөлс, урамшуулал зэрэг асуудлыг тусгасан байна.
- 10.4. Гүйцэтгэх захирал нь ТУЗ-ийн гишүүн байж болно.
- 10.5. Гүйцэтгэх захирал нь ТУЗ-өөс олгосон эрх хэмжээний хүрээнд компанийн нэрийн өмнөөс хэлцэл хийх, гэрээ байгуулах зэрэг Компанийн тухай хууль болон энэ дүрэмд зааснаар компанийг бүхий л харилцаанд итгэмжлэлгүйгээр төлөөлнө.
- 10.6. Гүйцэтгэх захирал нь албан тушаалаасаа чөлөөлөгдөх хүснэгтээ хувьцаа эзэмшигчид болон ТУЗ-д нэг сарын өмнө бичгээр мэдэгдсэнээр ТУЗ-ийн хурлаар авч хянан хэлэлцэнэ.

- 10.7. ТУЗ Гүйцэтгэх захирлын бүрэн эрхийг зогсоох, хязгаарлах эрхийг хэзээ ч хязгаарлаж болно.
- 10.8. Гүйцэтгэх захирлын жил бүрийн гүйцэтгэлийн үнэлгээг холбогдох хороогоор хэлэлцэж, ТУЗ-д тухай бүр тайлагнаж ажиллана.

АРВАН НЭГ. КОМПАНИЙН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН, ТҮҮНИЙ ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА

- 11.1. Компанийн тухай хуулийн 84.1-т заасан албан тушаалд ажиллах ажилтныг Компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцно. Эрх бүхий албан тушаалтнаар томилогдох этгээд нь Санхүүгийн зохицуулах хорооноос батласан Тохиромжтой этгээдийн шаардлагыг хангасан байна.
- 11.2. Компанийн эрх бүхий албан тушаалтан нь дараах үүрэгтэй. Үүнд:
 - 11.2.1. Компанийн тухай хууль, энэхүү Дүрэм, ТУЗ-өвс баталсан дотоод журамд заасан бүрэн эрхийн хүрээнд ажиллаж, Компанийн эрх ашгийг дээдлэх зарчмыг баримтална;
 - 11.2.2. ТУЗ-ийн зөвшөөрснөөс бусад тохиолдолд Компанийн нууцад хамрагдах мэдээ, тайлан, гэрээ, эрхийн холбогдолтой материалыг гуравдахь этгээдэд дамжуулах болон хувийн ашиг сонирхлын төлөө ашиглахгүй;
 - 11.2.3. шийдвэр гаргах, шийдвэр гаргах ажиллагаад оролцохдоо холбогдох бүх мэдээллийг бүрэн судалж, үндэслэл бүхий шийдвэр гаргах;
 - 11.2.4. шийдвэр гаргахдаа сонирхлын зөрчлөөс зайлсхийж, сонирхлын зөрчил үүссэн бол энэ тухайгаа заавал мэдэгдэж, шийдвэр гаргахад оролцохгүй байх;
 - 11.2.5. өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ гуравдагч этгээдээс бэлэг урамшуулал авахгүй, аливаа хэлбэрээр нэвтрээнд автахгүй байх;
 - 11.2.6. эрх бүхий албан тушаалд томилогдсоноос хойш ажлын 10 хоногийн дотор өөрийн нэгдмэл сонирхолтой этгээдийн нэrsийн жагсаалтыг ТУЗ-ийн нарийн бичгийн даргад өгөөд уг жагсаалтад гарсан өөрчлөлтийн талаар өөрчлөлт гарснаас хойш ажлын 10 хоногийн дотор мэдэгдэж байна.
- 11.3. Эрх бүхий албан тушаалтан нь албан тушаалаасаа өөрчлөгдсөнөөс хойш 3 жилийн хугацаанд энэ Дүрмийн 11.2.2-т заасан үүргийг хүлээнэ.
- 11.4. Албан тушаалтан энэ Дүрмийн 11.2 болон 11.3-т заасан үүргээ хэрэгжүүлээгүй, удаа дараа зерчсэн, мен тэдгээрийн дор дурдсан үйлдэл, эс үйлдлийн улмаас Компани, хувьцаа эзэмшигчид болон зээлдүүлэгчид, бусад оролцогч талуудад хохирол

- 14.12.3. компанийтай аудитаас бусад асуудлаар аливаа хэлцэл хийсэн этгээд бол;
- 14.13. Компанийн тухай хуулийн 97 дугаар зүйлийн 97.1-д заасан Компанийн бичиг баримтыг Компани нь хяналт шалгалт, лавлагаа, түүх, архивын зорилгоор холбогдох хуульд зааснаар хадгална.

АРВАН ТАВ. КОМПАНИЙГ ӨӨРЧЛӨН БАЙГУУЛАХ, ТАТАН БУУЛГАХ ТУХАЙ

- 15.1. Компанийг ХЭХ-ын шийдвэрээр буюу Компанийн тухай хуульд заасан бусад үндэслэлээр өөрчлен байгуулах (нэгдэх, нийлэх, хуваах, тусгаарлах, өөрчлен зохион байгуулах замаар) өөрчлен байгуулж болно.
- 15.2. Компанийг өөрчлен байгуулах асуудлыг Компанийн тухай хуулийн 18-24 дүгээр зүйлд заасан журмын дагуу шийдвэрлэнэ.
- 15.3. ХЭХ-ын шийдвэрээр Компанийг татан буулгах ажиллагааг ТҮЗ-вэс томилогдсон Татан буулгах комисс, хэрэв шүүхийн шийдвэрээр татан буугдаж байгаа бол шүүхээс томилсон хэрэг гүйцэтгэгч гүйцэтгэнэ.
- 15.4. Дор дурьдсан үндэслэлээр шүүх Компанийг татан буулгана
 - 15.4.1. Компани дампуурсан;
 - 15.4.2. Нэг ч гишүүн үлдээгүй;
 - 15.4.3. Хуульд заасан бусад үндэслэл;
- 15.5. Компанийг татан буулгах тохиолдолд нэхэмжлэгчийн нэхэмжлэлийг хангасны дараа үлдсэн херэнгэ (үүний дотор Компанийн эд херенгийг борлуулсны орлого мөн орно)-ийг Компанийн хуульд заасны дагуу хувьцаа эзэмшигчдэд хуваарилна.
- 15.6. Компанийг бүртгэх эрх бүхий байгууллага Улсын бүртгэлээс хассанаар татан буулгасанд тооцно.

АРВАН ЗУРГАА. БУСАД НӨХЦӨЛҮҮД

- 16.1. Энэхүү дүрэмд гагцхүү хувьцаа эзэмшигчдийн хурлын дийлэнх олонхийн шийдвэрээр нэмэлт, өөрчлөлт оруулж болно.
- 16.2. Энэхүү дүрэм болон холбогдох журамд шууд заагаагүй аливаа асуудлыг тухайн үед нь хүчин төгөлдөр үйлчилж байгаа Монгол Улсын хууль болон эрх зүйн бусад актаар зохицуулна.

*Газар Шим Үйлдвэр ХК-ийн Хувьцаа
эзэмшигчдийн эзэжсит бус хурлын 2023 оны
06 сарын 14-ний өдрийт №1 тоот Тогтоолын
Хавсралт №1*

- 16.3. Энэхүү дүрэм нь УБЕГ-ын Хуулийн этгээдийн Улсын бүртгэлийн газар бүртгүүлснээр хүчин төгөлдөр болж Компани татан буугдах буюу өөрчлөн байгуулагдах хүртэл хугацаагүй үйлчилнэ.
- 16.4. Энэхүү дүрэм нь Монгол хэл дээр 4 хувь үйлдэж, УБЕГ-ын Хуулийн этгээдийн Улсын бүртгэлийн газарт, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржид тус тус нэг нэг хувийг, Компанид нэг хувийг хадгална.

.....oooOOooo.....

“ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 06-р сарын 14-ний өдөр

№02

Улаанбаатар хот

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Ердийн болон
Хараат бус гишүүдийг сонгох тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь хэсэг, 77 дугаар зүйлийн 77.4 дэх хэсэг, 2023 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын Тооллогын комиссын тогтоол №2-т тус тус үндэслэн Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаас **ТОГТООХ НЬ:**

Нэг. ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР ХК-ийн (щаашид “компани” гэх) Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүнээр дараах этгээдүүдийг сонгосугай.

1.1. Ердийн гишүүдээр:

- 1.1.1. Монгол Улсын иргэн Цээпэлийн Ганбат
- 1.1.2. Монгол Улсын иргэн Шийтуугийн Алтанбагана
- 1.1.3. Монгол Улсын иргэн Цээпэлийн Төгсөө
- 1.1.4. Монгол Улсын иргэн Занаширын Байгалмаа
- 1.1.5. Монгол Улсын иргэн Дүгэржавын Сэргэлэн
- 1.1.6. Монгол Улсын иргэн Пүрэвсүхийн Нямдорж

1.2. Хараат бус гишүүдээр:

- 1.2.1. Монгол Улсын иргэн Ванчигийн Ганзориг
- 1.2.2. Монгол Улсын иргэн Чимэд-Очирын Баяртуул
- 1.2.3. Монгол Улсын иргэн Одхүүгийн Эрдэнэдалай

Хоёр. Хууль тогтоомж, компанийн засаглалын кодекс, Компанийн дүрэм болон ТУЗ-ийн үйл ажиллагаатай холбоотой дүрэм, журмуудыг мөрдеж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нийт гишүүдэд үүрэг болгосугай.

Гурав. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын шийдвэрийг хэрэгжүүлж хуульд заасан хугацаанд зохих журмын дагуу холбогдох бүртгэлийн байгууллагад хүргүүлж, бүртгүүлэхийг Гүйцэтгэх захирал /Ц.Ганбат/, Өмгөөлийн “Сноу Хилл Консалтганс” ХХН-ийн хуульч А.Солонго, А.Тайван нарт, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа удирдлага хариуцсан захирал албан тушаалтай /З.Байгалмаа/ нарт тус тус үүрэг болгосугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН

ХУРЛЫН ДАРГА



П.НЯМДОРЖ

**“ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТОГТООЛ**

2023 оны 06-р сарын 14-ний өдөр

№03

Улаанбаатар хот

**Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн
цалин, урамшууллын хэмжээ, төсвийг батлах тухай**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13, 62.1.15 дахь хэсэг, 2023 оны 06 дугаар сарын 14-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын Тооллогын комиссын тогтоол №2-г тус тус үндэслэн Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаас
ТОГТООХ НЬ:

Нэг. ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР ХК-ийн (цаашид “компани” гэх) Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээ, төсвийг Энэхүү тогтооолын нэгдүгээр хавсралтаар баталсугай.

Хоёр. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн цалин, урамшууллын зардал болон төсвийн зарцуулалтад хяналт тавьж ажиллахыг ТУЗ-ийн даргад үүрэг болгосугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ШИМ
ҮЙЛДВЭР ХК
ХУРЛЫН ДАРГА П.НЯМДОРЖ





ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮДИЙН ЦАЛИН, УРАМШУУЛЛЫН ХЭМЖЭЭ, ТӨСӨВ

№	Төсөв	1 хүний (1 удаа)	Давтамж	Нийт	Гишүүдийн тоо	Нийт
Цалин						
1	Цалин үндсэн-ТҮЗ-н дарга	1,500,000.00	12.00	18,000,000.00	1.00	18,000,000.00
2	Цалин үндсэн-ТҮЗ-н гишүүн	1,000,000.00	12.00	12,000,000.00	8.00	96,000,000.00
Урамшуулал						
3	Хорооны даргын нэмэгдэл	200,000.00	12.00	2,400,000.00	4.00	9,600,000.00
4	Даатгал	200,000.00	1.00	200,000.00	9.00	1,800,000.00
Бусад						
5	Бичиг хэргийн зардал	100,000.00	4.00	400,000.00	-	400,000.00
6	ТҮЗ-ын хурлын зардал	200,000.00	4.00	800,000.00	-	800,000.00
7	Үулзалт, тусгай арга хэмжээ, бусад	800,000.00	4.00	3,200,000.00	-	3,200,000.00
Жилийн нийт төсөв						129,800,000.00